

ХҮНИЙ НӨӨЦ НИЙГМИЙН ТӨЛӨШИЛ ТББ

**ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООНД ТҮШИГЛЭСЭН НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХЭД НӨХЦӨЛ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ ХИЙДЭГ
ЭСЭХЭД МОНИТОРИНГ ХИЙСЭН ТӨСЛИЙН ТАЙЛАН**

2014 он

ГАРЧИГ

МОНИТОРИНГИЙН ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА.....	3
МОНИТОРИНГИЙН ЗОРИЛГО	3
МОНИТОРИНГИЙН АРГАЧЛАЛ.....	3
МОНИТОРИНГИЙН ДҮН	5
ДҮГНЭЛТ	9
ЗӨВЛӨМЖ	10
НӨЛӨӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА.....	10

МОНИТОРИНГИЙН ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

“Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ” гэж иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоотойгоор өрх, иргэнд дэмжлэг туслалцаа, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг хэлнэ.¹

2012-2014 онд нэвтрүүлсэн нийгмийн халамжийн үйлчилгээний нэг хэлбэр болох олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ нь үйлчлүүлэгчдийг чадавхижуулах, тэд нарыг халамжийн тэтгэвэр, тэтгэмжид найдах биш, өөрөө өөрийгөө хөгжүүлэн амьдрах дадал зуршилтай болгоход чиглэсэн үйлчилгээ юм. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг нэвтрүүлэхээс өмнө нийгмийн халамжийн үйлчилгээ ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн зэрэг цөөн тооны зорилтот бүлгүүдэд тэтгэвэр, тэтгэмж олгоход чиглэж байсан бол одоо хүчрхийлэлд өртсөн иргэн, хорих ангиас суллагдсан иргэн, хүнд нөхцөлд байгаа хүүхэд гээд өөр өөрийн онцлог хэрэгцээтэй нийгмийн эмзэг бүлгийн хүмүүсийг хамрах болсон юм.

Эдгээр хүмүүсийн хэрэгцээнд нийцсэн, үр дүнтэй үйлчилгээ үзүүлэхийн тулд үйлчилгээг нөхцөл байдлын үнэлгээнд тулгуурлаж үзүүлэх нь нэн чухал юм. Нийгмийн халамжид хамрагдах өрх, иргэний нөхцөл байдлыг үнэлж, хөгжлийн төлөвлөгөөг тухайн өрх, иргэнтэй хамтран хийж, хэрэгжүүлэхийг 2008 оноос эхлэн Нийгмийн халамжийн тухай хуулиар нийгмийн ажилтны үүрэг болгон зохицуулжээ. Гэвч нөхцөл байдлын үнэлгээг хангалттай бус/огт хийдэггүйгээс үүдэн үйлчилгээний үр өгөөж төдийлөн сайн биш, зорилтот бүлгүүдийн хэрэгцээнд бүрэн нийцэхгүй тохиолдлууд гарсаар байна. Тиймээс олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэхдээ нийгмийн ажилтнуудын зүгээс нөхцөл байдлын үнэлгээ хийсэн байдалд мониторинг хийх нь чухал гэж үзэн Нээлттэй Нийгэм Форумын “Төрийн бус байгууллагуудын мониторинг” хөтөлбөрийн хүрээнд энэхүү мониторингийн төслийг хэрэгжүүллээ.

МОНИТОРИНГИЙН ЗОРИЛГО

Зорилго: Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх явцад “нийгмийн халамжид хамрагдах өрх, иргэний нөхцөл байдлыг үнэлж, хөгжлийн төлөвлөгөөг тухайн өрх, иргэнтэй хамтран хийж, хэрэгжүүлэх” тухай Нийгмийн халамжийн тухай хуулийн 28.8.2 дахь заалтыг хэрхэн хэрэгжүүлж байгаад мониторинг хийх.

МОНИТОРИНГИЙН АРГАЧЛАЛ

¹ Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.10-р заалт.

Мониторингийн хүрээнд Улаанбаатар хотын Баянзүрх, Баянгол, Сүхбаатар, Сонгинохайрхан болон Хан-Уул дүүргүүдэд 2013-2014 онд олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ авсан зорилтот бүлэг, иргэний 40 кейсийг судаллаа. Мониторингийн төслийг 2014 оны 2-р сараас 8-р сарын хооронд хэрэгжүүлсэн бөгөөд олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ авсан дараах зорилтод бүлгүүдийг хамруулсан юм:

- ахмад настан
- хөгжлийн бэрхшээлтэй иргэн
- өрх толгойлсон эмэгтэй
- хүчирхийлэлд өртсөн иргэн

Мониторингийн хүрээнд мэдээлэл цуглуулах дараах аргуудыг ашигласан болно:

1. Баримт бичгийн судалгаа- Нийгмийн халамжийн тухай хууль, Олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэх журам² ба холбогдох бусад дүрэм журам, дүүргүүдийн Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтэс (НХҮХ)-ээс 2013-2014 онд олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ авсан 80 гаруй иргэний хувийн хэрэг, хорооны халамжийн нийгмийн ажилтнуудын нөхцөл байдлын үнэлгээ хийсэн бичиг баримт болон олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлсэн ТББ-уудын бүртгэл мэдээлэл, тайлан зэрэг бичиг баримтуудыг судалсан болно. Баримт бичгийн судалгааны хүрээнд, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх эрхзүйн зохицуулалт болон түүний хэрэгжилтийн талаар мэдээлэл цуглуулав.
2. Ярилцлага- Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ авсан дээр дурдсан бүлэг, иргэдийн төлөөлөлтэй ярилцаж, тэд ямар төрлийн үйлчилгээ авсан, үйлчилгээ үзүүлэхдээ нийгмийн ажилтнууд тэдний хэрэгцээг судалсан эсэх, судалсан бол ямар арга ашигласан, тэд авсан үйлчилгээндээ сэтгэл хангалуун байгаа эсэх талаар ярилцсан юм. Түүнчлэн, нийслэл ба дүүргүүдэд олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг хариуцсан 5 мэргэжилтэн, 25 хорооны нийгмийн ажилтан, гурван дүүргийн НХҮХ-ийн Нийгмийн халамжийн албаны дарга, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлсэн 10 төрийн бус байгууллага (ТББ)-ын төлөөлтэй ярилцлаа. Эдгээр уулзалтуудын хүрээнд, 2013-2014 онд олон нийтийн оролцоонд түшиглэсэн ямар төрлийн халамжийн үйлчилгээг иргэдэд үзүүлсэн, ингэхдээ нөхцөл байдлын үнэлгээ хийсэн эсэх, хийсэн бол ямар арга ашигласан, хийгээгүй бол үүний учир шалтгаан зэргийг тодруулсан юм.

² Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 162-р тогтоолын 4-р хавсралт
<http://www.legalinfo.mn/annex/showPrint/2370>

3. Ажиглалт- Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ авсан зорилтот бүлэг, иргэний 40 кейс судалгааны хүрээнд сонгон авсан бүлэг, иргэдийн нөхцөл байдал, дүүрэг, хороодын нийгмийн ажилтнуудын ба гэрээний дагуу үйлчилгээ үзүүлж буй ТББ-ын үйл ажиллагааны орчинг ажигласан болно. Тухайлбал, олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээний талаарх мэдээллийг иргэдэд хүргэж буй арга, үйлчилгээний холбогдолтой бичиг хэргийн хөтлөлт зэргийг ажиглаллаа.

МОНИТОРИНГИЙН ДҮН

Нийгмийн халамжийн тухай хуулийн 18.1 болон 18.2-т олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн 9 төрлийн үйлчилгээг 10 зорилтод бүлэгт үзүүлэхээр заасан байна.

Дүүргийн байршил, хүн амын бүтэц зэргээс хамаараад мониторингод хамруулсан Баянзүрх, Баянгол, Сүхбаатар, Сонгинохайрхан болон Хан-Уул дүүрэгт иргэдэд үзүүлсэн олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний төрөл харилцан адилгүй байна.

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэх журамд зааснаар нөхцөл байдлын

18.2: Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд дараах өрх, иргэн хамрагдана:

- 18.2.1: ахмад настан;
- 18.2.2: хөгжлийн бэрхшээлтэй иргэн;
- 18.2.3: хүнд нөхцөлд байгаа хүүхэд;
- 18.2.4: хүчихрийлэлд өртсөн иргэн;
- 18.2.5: хорих ангиас суллагдсан иргэн;
- 18.2.6: согтууруулах, мансуурах донтох өвчтэй иргэн
- 18.2.7: эдгэшгүй хүн өвчтэй хүн;
- 18.2.8: гэр оронгүй тэнэмэл амьдралтай өрх, иргэн;
- 18.2.9: шилжин суурьшсан, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн;
- 18.2.10: өрх толгойлсон эх /эцэг/.

18.1: Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ нь дараах төрөлтэй байна:

- 18.1.1: амьдралын итгэл үнэмшил, бие даан амьдрах чадвар, хөдөлмөрийн дадал олгох, авьяасыг нь дэмжих зорилгоор сургалт зохион байгуулах;
- 18.1.2: зөвлөгөө өгөх;
- 18.1.3: сэргээн засах үйлчилгээнд хамруулах;
- 18.1.4: түр байрлуулан асрамжлах;
- 18.1.5: өдрийн үйлчилгээнд хамруулах;
- 18.1.6: гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд хамруулах;
- 18.1.7: иргэн, түүний гэр бүлийн хэрэгцээнд тулгуурласан нийгмийн халамжийн бусад үйлчилгээ үзүүлэх;
- 18.1.8: гэр оронгүй иргэн, түүний гэр бүлийн гишүүдийн амьдрах итгэлийг нэмэгдүүлэх, нийгэмшүүлэх, бичиг баримтжуулах, түр хоноглох байранд байрлуулах;
- 18.1.9: нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай энэ хуулийн 3.1.2, 18.2-т заасан өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах.

үнэлэгээг хорооны нийгмийн ажилтан хийх ёстой боловч энэ журмын хэрэгжилт ямар байгааг мониторингийн хүрээнд хийсэн кейс судалгааны жишээнд тулгуурлан дор танилцуулж байна:

18.1.1: Амьдралын итгэл үнэмшил, бие даан амьдрах чадвар, хөдөлмөрийн дадал олгох, авьяасыг нь дэмжих зорилгоор сургалт зохион байгуулах үйлчилгээг мониторингод хамруулсан бүх дүүрэгт үзүүлсэн байна.

Баянгол, Баянзүрх болон Сүхбаатар дүүрэгт энэ үйлчилгээг хүртсэн 5 иргэний кейс судалж

үзэхэд, тэд 40-65 настай, 2 нь өрх толгойлсон эмэгтэй, 3 нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд байлаа. Эдгээр иргэд хорооны нийгмийн ажилтнаас мэдээлэл авч, дараах сургалтад хамрагдсан байна:

- цэцэг тарих, зүлэг ногоо арчлах
- биеэ зөв авч явах, өөртөө итгэлтэй болох болон
- гэрийн үйлчлэгч, цэцэрлэгчийн туслах багшийн сургалт

Сургалтыг НХҮЕГ-аас зарласан тендерт шалгарсан, сургалт явуулах эрхтэй ТББ-аар дамжуулан дүүргийн НХҮХ-үүд зохион байгуулжээ. Үйлчилгээг үзүүлэхдээ хорооны нийгмийн ажилтнууд нөхцөл байдлын үнэлгээ хийгээгүй байна. Энэ үйлчилгээг авсан 5 иргэн бүгд амьжиргаагаа дээшлүүлэх зорилгоор сургалтад хамрагдсан тухай ярилцлагын үеэр хэлсэн. Гэвч Сүхбаатар, Сонгинохайрхан ба Баянгол дүүрэгт хийсэн сургалтын хүрээнд хүрээлэн буй орчин ба амьдралын талаарх ерөнхий мэдээлэл олгосон нь иргэдийн хэрэгцээнд нийцээгүй сургалт болжээ:

“Сургалт амьдралд хэрэгтэй байвал зүгээр юм. Амьжиргаа дээшлүүлэхэд хувь нэмэр оруулахуйц байвал зүгээр байна. Гэрээрээ юм хийж амьжиргаагаа дээшлүүлэх хүсэлтэй байгаа учраас энэ чиглэлийн сургалт хэрэгцээтэй байна.”

Сүхбаата ба Баянгол дүүргийн оршин суугчид

Харин Баянзүрх дүүрэгт сургалт зохион байгуулсан ТББ нь оролцогчдод гэрийн үйлчлэгч, цэцэрлэгийн туслах багшийн үнэмлэх олгох сургалт зохион байгуулсанд иргэд сэтгэд ханамжтай байгаагаа илэрхийлж байв.

18.1.2: Зөвлөгөө өгөх үйлчилгээг мониторингод хамруулсан бүх дүүрэгт 2-3 ТББ гэрээний дагуу тус тус үзүүлсэн байна.

Баянгол дүүрэгт зөвлөгөө авсан 6 иргэний кейсээс харахад, тэд ахмад настай ба хөгжлийн бэрхшээлтэй иргэд бөгөөд тэдний 4 нь энэ үйлчилгээнд хамрагдсан тухай мэдэхгүй байсан юм. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчилгээ үзүүлсэн ТББ нь иргэд бие биедээ зөвлөгөө өгөх болон бүлгээр сэтгэл засал хийх хэлбэрийг сонгосон байна. Бүлгээр зөвлөгөө өгч, засал хийх нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгэмшлийг дэмжих, оролцоог нэмэгдүүлэх ач холбогдолтой гэж үйлчилгээ үзүүлсэн ТББ болон үйлчилгээ авсан иргэд сайшаан дүгнэж байлаа. Нөгөөтгээгүүр, ахмад настангуудад зөвлөгөө өгсөн ТББ-ын тайлангаас харахад, үйлчилгээ авахаар хандсан хүмүүст амьдралын утга учиртай холбоотой зөвлөгөө өгчээ. Зөвлөгөө авсан зарим ахмад настангууд хүүхдүүддээ ажил олох талаар зөвлөгөө авах хүсэлтэй байсан тухай ярьж байлаа. Эдгээр хоёр бүлэг иргэдэд зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлэхэд аль ч тохиолдолд нөхцөл байдлын үнэлгээг тусгайлан хийгээгүй, мөн үйлчилгээ үзүүлсний дараа түүний чанар, хэрэгцээг үнэлж байгаагүй байна.

18.1.3: Сэргээн засах үйлчилгээг мониторингод хамруулсан бүх дүүрэгт үзүүлж байгаа бөгөөд энэ үйлчилгээ олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн халамжийн нийт үйлчилгээний 85-90 хувийг эзэлж байна.

Сэргээн засах үйлчилгээний хүрээнд массаж, нөхөн сэргээх эмчилгээ, мөн зүү төөнүүр, бариа засал зэрэг уламжлалт анагаах ухааны эмчилгээний хэлбэрүүд багтаж байгаа бөгөөд энэ үйлчилгээг ихэвчлэн хөгжлийн бэрхшээлтэй иргэд ба ахмад настангууд авч байна. Сэргээн засах үйлчилгээг мөн ТББ-ууд үзүүлдэг бөгөөд хорооны нийгмийн ажилтнууд нөхцөл байдлын үнэлгээ хийдэггүй, харин дүүргийн НХҮХ-ээс ТББ-уудад мэдээлэл өгөх, үйл ажиллагаанд нь хяналт тавих байдлаар ажилладаг байна. Үйлчилгээ үзүүлэгч ТББ нь сэргээн засах үйлчилгээ авахаар хандсан иргэдэд эрүүл мэндийн үзлэг хийсний үндсэн дээр шаардлагатай гэж үзсэн эмчилгээг хийдэг байна. Үйлчилгээний үр өгөөжийг зөвхөн иргэдийн сэтгэл ханамжийн судалгаанд тулгуурлан хийж байгаа бөгөөд үйлчлүүлэгчдийн хэрэгцээг тодорхойлох, үйлчилгээний үр дүнг үнэлэхэд нийгмийн халамжийн байгууллагаас арга зүйн дэмжлэг авах шаардлага байгааг ТББ-ууд хэлж байлаа.

Сэргээн засах үйлчилгээнд хамрагдсан Баянзүрх, Баянгол, Сүхбаатар, Сонгинохайрхан ба Хан-Уул дүүргийн 10 иргэдийн кейсээс харахад тэд авсан үйлчилгээндээ бүгд сэтгэл хангалуун байна. Эмнэлгийн үйлчилгээ хангалтгүй байгаа энэ үед нийгмийн халамжийн үйлчилгээний хүрээнд сэргээн засах үйлчилгээг багтаасан нь зөв алхам болсныг тэд онцолж, үйлчилгээнд хамрагдсаны дүнд эрүүл мэнд нь сайжирсан тухай хэлж байсан юм. Үйлчилгээ авч байсан ярилцсан бүгд маш сэтгэл хангалуун байсан эмнэлэгийн үйлчилгээ муу байгаа үед нөхөн сэргээх эмчилгээг халамжийн салбарынхан хийж байгаа нь таалагдсан. эрүүл мэнд нь дээшилж байгааг илэрхийлсэн Зөвхөн эмнэлэгийн нөхөн сэргээлт хийж байгаа нь хангалтгүй байна. ЭМ-ийн салбарын үйлчилгээтэй давхцаж байна.

18.1.4: Түр байрлуулан асрамжлах үйлчилгээг мониторингод хамруулсан 5 дүүрэгт хүчирхийлэлд өртсөн хүүхэд, эмэгтэйчүүдийг хамруулан үзүүлжээ. Улаанбаатар хотод тус үйлчилгээг дүүргийн НХҮХ-тэй гэрээ байгуулсаны үндсэн дээр нэг ТББ бие даан хүргэж байна. 2013-2014 онд нийт 37 эмэгтэй, 53 хүүхдэд түр байрлуулан асрамжлах үйлчилгээ үзүүлсэн бөгөөд тус байгууллага нь үйлчилгээнд хамрагдсан иргэдэд хувийн хэрэг нээж, нөхцөл байдлын үнэлгээ хийгээд дүүргийн НХҮХ-т хүргүүлжээ. Харин нөхцөл байдлын үнэлгээ хийх ёстой хорооны нийгмийн ажилтнууд үнэлгээ хийгээгүйгээс гадна үйлчилгээ авсан эмэгтэйчүүдийг мэдэхгүй байх тохиодол нэлээдгүй байна.

Түр байрлуулан асрамжлах үйлчилгээ авсан 5 хүний кейс судлахад тэд Баянзүрх, Сүхбаатар болон Сонгинохайрхан дүүргийн харъяат, бүгд эмэгтэй үйлчлүүлэгчид байв. Эдгээр эмэгтэйчүүд дунджаар 3-6 жилийн туршид хүчирхийлэлд өртөж байгаа бөгөөд үйлчилгээ үзүүлэгч ТББ-ын талаарх мэдээллийг найз нөхөд, хэвлэл мэдээллийн хэрэгслээс сонсч, түр байруулан асрамжлаж үйлчилгээ авахаар хандсан тухай хэлж байлаа:

- “Хорооны нийгмийн халамжийн ажилтанд хүчирийлэлд өртсөн талаар хандаж байгаагүй. Тэд намайг мэддэг боловч над дээр ирж байгаагүй, би ч очиж байгаагүй.”

Баянзүрх, Сонгино хайрхан, Хан-Уул ба Баянгол дүүргийн оршин суугчид

- “Хамгаалах байранд ирсэн зарим эмэгтэйчүүдийг нийгмийн ажилтан нь явуулсан байсан. Энэ тухай сонсоод нийгмийн ажилтанд хандаж болно гэдгийг мэдсэн.”

Баянгол дүүргийн оршин суугч

18.1.8: Гэр оронгүй иргэн, түүний гэр бүлийн гишүүдийн амьдрах итгэлийг нэмэгдүүлэх, нийгэмшүүлэх, бичиг баримтжуулах, түр хоноглох байранд байрлуулах үйлчилгээг мониторингод хамруулсан хоёр дүүрэг хэрэгжүүлсэн байна.

Баянзүрх болон Сонгинохайрхан дүүрэгт тус үйлчилгээг гэрээний дагуу үзүүлдэг ТББ-д үйлчлүүлэгчдийн нөхцөл байдлын үнэлгээг хийсэн байна. Энэ үйлчилгээг хүртсэн 5 иргэний кейс судлахад, тэд хороо эсхүл дүүргийн нийгмийн халамжийн ажилтантай уулзаж байгаагүй бөгөөд үйлчилгээний талаарх мэдээллийг найз нөхөд болон цагдаагийн байгууллагаас авсан тухай хэлсэн юм. Мониторингийн явцад уулзсан нийгмийн ажилтнуудтай ярилцахад энэ үйлчилгээг үзүүлсэн эсхүл нөхцөл байдлын үнэлгээ хийснийг нотлох баримт тэд нарт байхгүй байсан нь нийгмийн халамжийн ажилтнууд үйлчилгээ үзүүлэхэд оролцдоггүйг баталж байгаа юм. Харин ТББ-аас үзүүлж байгаа түр хоноглох байранд байрлуулах болон бичиг баримтжуулах үйлчилгээг иргэд сайшааж байсан бол нийгэмшүүлэх болон гэр бүлийн гишүүдийн амьдрах итгэлийг нэмэгдүүлэх үйлчилгээг цаашид сайжруулах шаардлагатай гэж үзэсэн байна.

18.1.9: Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай, хуулийн 18.2-т заасан өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах үйлчилгээг мониторингод хамруулсан бүх дүүрэгт хэрэгжүүлсэн байна.

Сүхбаатар, Хан-Уул болон Баянзүрх дүүрэгт энэ үйлчилгээнд хамрагдаж, төсөл хэрэгжүүлсэн 7 бүлэг иргэдийн кейсээс харахад тэд ихэвчлэн ах дүүс зэрэг хамаатан садангийн холбоотой, 40-оос дээш настай иргэд бөгөөд нэг бүлэг дунджаар 2-4 гишүүнтэй байна. Үйлчилгээний талаарх мэдээллийг иргэд ихэвчлэн таньдаг хүмүүсээс сонсч, төслөө бичиж, хорооныхоо нийгмийн ажилтанд хүргүүлдэг байна. Хорооны нийгмийн ажилтнаас ирүүлсэн төслийг дүүргийн НХҮХ-ийн хариуцах нийгмийн ажилтан нь хянаж, санхүүжилт олгох шийдвэрийг НХҮХ-ийн дарга, Гэр бүлийн хөгжил, нийгмийн халамжийн албаны дарга ба санхүүгийн ажилтнаас бүрдсэн баг гаргажээ. Ингэхдээ тэд газар дээр нь очиж, төсөл хэрэгжүүлэх хүсэлт гаргасан иргэдийн нөхцөл байдлыг судалсан байна. Гэвч кейс судалгаанд хамруулсан 25 нийгмийн ажилтнаас зөвхөн 6 нь нөхцөл байдлын үнэлгээ хийснийг нотлох тэмдэглэл, тайланг үзүүлсэн бөгөөд үнэлгээ хийхдээ бүлгийн гишүүдийн хөдөлмөрийн чадамж, төсөл хэрэгжүүлсэнээр бий болох ажлын байрны тоонд үндэслэж дүгнэлт хийжээ. Кейс

судалгаанд хамруулсан 7 бүлэг иргэд дараах чиглэлээр төсөл хэрэгжүүлсэн байна:

- эсгий урлал (2)
- гэрийн тавилга, сийлбэр (1)
- монгол дээл оёх (3)
- гутлын үйлдвэрлэл (1)

Дүүргийн НХҮХ-үүд төсөл хэрэгжүүлж буй бүлгүүдтэй нэг жилийн гэрээ байгуулж, төслийн хэрэгжилтийн талаарх тайланг улирал тутам авч, хянадаг байна. Төсөл хэрэгжүүлсэн иргэд хүссэн чиглэлээрээ төсөл хэрэгжүүлж, орлогын эх үүсвэртэй болсондоо сэтгэл хангалуун байгаагаа ярьж байв.

Хорооны нийгмийн ажилтнууд нөхцөл байдлын үнэлгээ хийхгүй байгаа шалтгаан

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэхдээ хорооны нийгмийн ажилтнууд нөхцөл байдлын үнэлгээ хийхгүй байгаагаа дараах шалтгаанаар тайлбарлаж байна:

- нөхцөл байдлын үнэлгээ хийх мэдлэг, туршлага дутмаг
- шинээр ажилд ороод удаагүй байгаа
- ажлын ачаалал их учраас хийж амждаггүй

ДҮГНЭЛТ

Нийгмийн халамжийн тухай хуулийн “нийгмийн халамжид хамрагдах өрх, иргэний нөхцөл байдлыг үнэлж, хөгжлийн төлөвлөгөөг тухайн өрх, иргэнтэй хамтран хийж, хэрэгжүүлэх” гэсэн 28.8.2 дахь заалт олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээг үзүүлэх явцад бүрэн хэрэгжихгүй байна:

1. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн зарим халамжийн үйлчилгээг үзүүлэхийн өмнө нөхцөл байдлын үнэлгээ хийдэггүй учраас үйлчилгээ нь иргэдийн хэрэгцээнд нийцэхгүй байх тохиолдлууд гарч байна.
2. Зарим үйлчилгээг үзүүлэхдээ нөхцөл байдлын үнэлгээ хийдэг боловч үүнийг хууль тогтоомжид заасанчлан хорооны нийгмийн ажилтан бус, дүүргийн НХҮХ-тэй гэрээ байгуулсан ТББ эсхүл дүүргийн нийгмийн халамжийн хэлтсийн ажилтнуудаас бүрдсэн баг хийж байна.
3. Нөхцөл байдлын үнэлгээ хийх мэдлэг, туршлага хангалтгүй, мөн ажлын ачаалал их байдаг учраас хорооны нийгмийн ажилтнууд нөхцөл байдлын үнэлгээ хийдэггүй байна.
4. Нөхцөл байдлын үнэлгээ хийх тогтсон арга зүй, удирдамж байдаггүй тул үйлчилгээ авахаар хандсан иргэдийн бодит хэрэгцээг тодорхойлж чадаж байгаа эсэх нь эргэлзээтэй байна.

5. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний талаарх мэдээллийн хүртээмж хангалтгүй, мэргэжилтнүүдийн ойлголт мэдлэг дутагдалтай байна.

ЗӨВЛӨМЖ

Дээрх дүгнэлтэд үндэслэн олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээг үзүүлэх явцад Нийгмийн халамжийн тухай хуулийн 28.8.2 дахь заалтын хэрэгжилтийг сайжруулахын тулд дараах зөвлөмжийг гаргаж байна:

1. Нийгмийн хорооны ажилтнуудад нөхцөл байдлын үнэлгээ хийх үүргийг хүлээлгэсэн Засгийн газрын 2008 оны 162-р тогтоолын хэрэгжилтийг хангах.
2. Нөхцөл байдлын үнэлгээ хийх арга зүйг үйлчилгээ тус бүрийн тухайд боловсруулж, нийгмийн хорооны ажилтнуудыг нөхцөл байдлын үнэлгээ хийх сургалтад хамруулж, дадлагажуулах.
3. Үйлчилгээний үр дүнг тооцох оновчтой арга боловсруулж, үүний үндсэн дээр үйлчилгээг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх.
4. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний талаарх мэдээллийн хүртээмжийг сайжруулах талаар хорооны нийгмийн ажилтнууд илүү идэвхтэй ажиллах.
5. Үйлчилгээ үзүүлж буй ТББ-уудтай хамтран ажиллаж арга зүй аргачлалаар хангаж ажиллах

НӨЛӨӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг хариуцсан нийгмийн ажилтнуудад анхан шатны дүгнэлтийг танилцуулсан.

Нийслэлийн халамж үйлчилгээний газарт анхан шатны тайлангийн хувилбарын хураангуйг хүргүүлсэн.

Цаашдаа хийхээр төлөвлөж байгаа нөлөөллийн үйл ажиллагаа

Тайланг хэвлэн нийгмийн халамж үйлчилгээний удирдлагууд болон мэргэжилтнүүдийн дунд танилцуулах.

Мэргэжлийн олон нийтийн хүртээл болгох

Мэргэжилтнүүдийн санаа бодлыг нэгтгэн зөвлөмж боловсруулахыг уриалах